



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын хураангуй тайлан

АУДИТЫН СЭДЭВ: “ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ”

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ: ДОТООДЫН ХЯНАЛТ САЙЖРУУЛЖ ҮР АШИГГҮЙ ЗАРДЛЫГ БУУРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Аудитын тайланг хүргүүлсэн этгээд: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, “Баян-Өлгий аймгийн Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ, “Суат” ХХК, ААН-ийн Төлөөлөн удирдах зөвлөл

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: У.Ербол

Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Нурлан

Утас: 99103281, Цахим хаяг Nurlans@audit.gov.mn

Аудитор: М.Айнур

Утас: 99423031 Цахим хаяг: ainurm@audit.gov.mn

Аудитор: Х.Еркебулан

Утас: 99999844 Цахим хаяг: erkebulankh@audit.gov.mn

Аудитор: Р. Баярмаа

Утас: 99265539 Цахим хаяг: Bayarmaar@audit.gov.mn

Аудитор: Ш.Нурлан

Утас: 99422966 Цахим хаяг: NurlanSH@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuyab@audit.gov.mn

Аудитор Ж.Назгүл

Утас: 99668909, Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

2025 оны 11 дүгээр сар

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн гүйцэтгэв

Аудитын зорилго, зорилтууд, хамарсан хүрээ:

Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх;
- Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн хяналт үр нөлөөтэй эсэх

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай хууль, УИХ, Засгийн газраас гаргасан тогтоол, тухайн хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтыг хэрэгжүүлэхэд оролцогч, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, “Цахилгаан шугам сүлжээний газар” ОНӨААТҮГ, “Суат” ХХК-ийн 2023-2024 оны үйл ажиллагааг хамруулав.

Аудит хийхэд гарсан хүндрэл бэрхшээл: Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн удирдлагад ажиллаж байсан зарим албан тушаалтнууд ажлаас гарсан, албан тушаал өөрчлөгдснөөс аудитад шаардлагатай баримт материал гаргуулж авах, тайлбар тодруулга авах, гаалийн байгууллагаас тодруулах мэдээлэл авахад хугацаа шаардсан зэрэг хүндрэл учирсан.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн: Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор У.Ербол, С.Нурлан, аудитор М.Айнур, Ж.Назгүл, Б.Үүрийнтуяа, Х.Еркебулан, Р.Баярмаа, Ш.Нурлан нар хамтран гүйцэтгэв.

Аудитын гол үр дүн:

БҮЛЭГ 1. ОНӨААН-ҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН ҮР АШИГГҮЙ БАЙНА

1.1.ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ХЯНАЛТ НЬ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

1.1.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бодлого, шийдвэрийн үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна

Цахилгаан шугам сүлжээний газрын ТУЗ нь компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах талаар бодлого, шийдвэр гаргаж ажиллаагүй байна. Аймгийн ИТХ-ын 2025.01.27-ны өдрийн 38 дугаар тогтоолоор Цахилгаан шугам сүлжээний газрын дүрэм, ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, ТУЗ-ийн эрх, үүргийн талаар тусгаж улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

“Суат” ХХК-ны Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 онд 6 удаа хуралдаж 10 удаагийн, 2024 онд 2 удаа хуралдаж 5 удаагийн тогтоолоор холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажилласан ба тогтоол, шийдвэрүүдээс харахад компанийн үйл ажиллагааг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх, ажилладагсдын нийгмийн асуудлыг дээшлүүлэх талаар оновчтой бодлого шийдвэр гаргаж ажиллаагүй байна

1.1.2. Эдийн засгийн зорилтот түвшний зарим үзүүлэлтийг бодитой төлөвлөөгүй байна

“ББЭХ-ний систем” ХХК-аас 2023 онд 78.35 сая кВт/цаг, 2024 онд 81.40 сая квт/цаг цахилгаан худалдаж авахаар төлөвлөсөн байна. Үүнээс түгээлтийн алдагдлыг хасаж тооцоход 2023 онд 65.69 сая кВт/цаг, 2024 онд 68.40 сая кВт/цагийн цахилгаан борлуулахаар төлөвлөжээ.

ЦШСГ нь 2023 онд нийтдээ 16,046.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 15,935.1 сая төгрөгийн зардал гаргаж 111.1 сая төгрөгөөр ашигтай ажиллахаар, 2024 онд нийтдээ 14,687.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж 14,687.5 сая төгрөгийн зардал гаргаж ашиг, алдагдлыг тэг байхаар төлөвлөжээ.

Үйл ажиллагааны бус орлогыг 2023 онд өмнөх оноос 27.2%-иар буюу 111.1 сая төгрөгөөр бууруулж, 2024 онд төлөвлөөгүй байна.

Илрүүлэлт:

Шинэ хэрэглэгчийн холболтоос орох техникийн нөхцөлийн орлого, цахилгаан тасалсны орлого, алданги зэрэг үйл ажиллагааны бус орлогыг 2024 онд төлөвлөгөөгүй байгаа нь төлөвлөлтийг дутуу хийснийг харуулж байна.

Нийт зардлыг 2023 онд өмнөх оноос 30.4%-иар буюу 6,434.2 сая төгрөгөөр, 2024 онд 16.6%-иар буюу 2,155.8 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн байна. Үүнээс үйл ажиллагааны зардал (тарифт зардал)-ыг 2023 онд 34.4%-иар буюу 2,253.6 сая төгрөг, 2024 онд 30.3%-иар буюу 1,458.0 сая төгрөгөөр нэмж төлөвлөжээ.

“Суат” ХХК нь 2023 онд 1,518.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,655.1 сая төгрөгийн зардал гаргаж, 137.2 сая төгрөгийн алдагдалтай, 2024 онд 2,252.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,185.4 сая төгрөгийн зардал гаргаж, 66.7 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн байна.

2024 онд орлогыг өмнөх оноос 734.0 сая төгрөгөөр буюу 48.4 хувиар, зардлыг 530.0 сая төгрөгөөр буюу 32 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн. Нийт орлогын өсөлт нь зардлын өсөлтөөс 16.3 хувиар их байхаар тооцож, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг 28.7 хувиар, ерөнхий ба удирдлагын зардлыг 48.9 хувиар нэмэгдүүлэн төлөвлөжээ.

Ерөнхий ба удирдлагын зардлыг 2023 онд 11.2 хувиар, 2024 онд 48.7 хувиар өсгөж төлөвлөсөн нь борлуулсан бүтээгдэхүүний өртгийн өсөлтөөс 4.2-29.0 хувиар өндөр байна.

1.1.3. ЦШСГ-ын зорилтот түвшний зарим үзүүлэлтийг бодитой хянаагүй байна

Цахилгаан шугам сүлжээний газрын 2023-2024 оны бизнес, санхүүгийн төлөвлөгөөг ЭХЗХ-ын Үнэ тарифын газрт хянуулж ажилласан байна.

ЭХЗХ-ны ҮТГ-аас 2023 онд худалдан авах, борлуулах цахилгааны кВт/цагийг хэвээрээ баталж борлуулалтын орлогыг 463.2 сая төгрөгөөр (дундаж үнийг 7 төгрөгөөр) бууруулж, 2024 онд худалдан авах, борлуулах цахилгаан болон борлуулалтын орлогын хэмжээг хэвээр нь баталсан байна.

ЦШСГ-ын 2023 оны нийт орлогын төлөвлөгөөг 1,258.4 сая төгрөгөөр, үүнээс борлуулалтын орлогыг 463.2 сая төгрөгөөр, түгээх үйлчилгээний орлогыг 795.8 сая төгрөгөөр бууруулж, үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. 2024 оны нийт орлогыг 295.0 сая төгрөгөөр бууруулж, үүнээс түгээх үйлчилгээний орлогыг 409.8 сая төгрөгөөр бууруулж, үндсэн үйл ажиллагааны орлогыг 114.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үнэ тарифын газраас 2023 оны нийт зардлыг 1,259.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна

Илрүүлэлт:

Удирдах зөвлөл нь ЦШСГ-ын 2023 оны бизнес төлөвлөгөөг баталсан боловч техник, эдийн засгийн үзүүлэлт бүрээр хэлэлцэж хавсралтаар батлаагүй, мөн 2024 оны бизнес төлөвлөгөөг батлаагүй, хяналтыг тавьж ажиллаагүй байна.

“Суат” ХХК-ны 2023 оны үйл ажиллагааны болон санхүү, бизнес эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 01 дүгээр тогтоолоор, 2024 оны үйл ажиллагааны болон санхүү, бизнес эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 01 дүгээр тогтоолоор баталсан.

Төлөөлөн удирдах зөвлөлд компанийн 2023, 2024 оны үйл ажиллагаа болон бизнес, эдийн засгийн тайланг хүргүүлж, хэлэлцүүлжээ.

Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээний зохицуулах хороонд компанийн үйл ажиллагаа болон бизнес, зэдийн засгийн төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнаж ажилласан байна.

.2. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮР ДҮНТЭЙ, ҮР АШИГТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР ХАНГАЛТГҮЙ АЖИЛЛАСАН БАЙНА.

1.2.1. Үйл ажиллагааны зорилт түвшнийг хангаж ажиллах шаардлагатай байна

ЦШСГ-ын нийт орлого гүйцэтгэлээр 2023 онд 99.7 сая төгрөг буюу 0.3 %-иар буурсан бол 2024 онд 1,293.8 сая төгрөг буюу 7.8%-иар өссөн байна. Үүнээс: борлуулалтын орлого 2023 онд 274.1 сая төгрөгөөр буюу 2.5%-иар буурч, 2024 онд 961.0 сая төгрөгөөр буюу 8.1 %-иар өссөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 2023 онд 240.4 сая төгрөгөөр буюу 1.6%-иар хэмнэлттэй, 2024 онд 1,250.1 сая төгрөгөөр буюу 7.6%-иар хэтрэлттэй гарсан байна.

Цалин, НДШ-ийн зардал 2023 онд 22.6 сая төгрөгөөр, элэгдлийн зардал 149.1 сая төгрөгөөр хэтэрсэн, 2024 онд цалин, НДШ-ийн зардал 1.7 сая төгрөгөөр хэмнэгдэж, элэгдлийн зардал 202.9 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

ЦШСГ нь 2023 онд 227.2 сая төгрөгийн, 2024 онд 142.7 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажиллажээ.

Нийт авлага 2023 онд 215.6 сая төгрөгөөр буурч, 2024 онд 662.3 сая нэмэгдсэн байна. Үүнд: Гэр хорооллын авлага 279.7 сая төгрөгөөр, ААНБ-ийн авлага 358.3 сая төгрөгөөр, бусад авлага 62.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлага өсөхөд нөлөөлсөн байна

БХӨТ нь 2023 онд өмнөх оноос 720.5 сая төгрөгөөр, 2024 онд 513.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

“Суат ХХК” нь 2023 онд гүйцэтгэлээр нийтдээ 1,668.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,760.4 сая төгрөгийн зардал гаргаж, 91.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Төлөвлөснөөс орлого 150.8 сая төгрөгөөр өссөн боловч зардал нь 105.3 сая төгрөгөөр хэтэрч, алдагдал нь төлөвлөсөн хэмжээнээс 45.5 сая төгрөгөөр буурсан байна.

2024 онд гүйцэтгэлээр нийтдээ 2,339.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,129.1 сая төгрөгийн зардал гаргаж, 210.7 сая төгрөгийн ашигтай ажилласан. Орлого нь төлөвлөснөөс 87.7 сая төгрөгөөр өсөж, зардлыг 56.3 сая төгрөгөөр хэмнэж, төлөвлөсөн ашгийн хэмжээ 144.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Цэвэр, бохир усны шугамд холбогдсон хэрэглэгчийн тоо нэмэгдэж, үнэ тариф өссөн нь орлого өсөхөд нөлөөлсөн байна. Тухайлбал: 2023 онд 18 төсвийн байгууллага, 31 аж ахуйн нэгж, 181 айл, өрх шинээр холбогдсон бол 2024 онд 14 аж ахуйн нэгж, 242 айл, өрх шинээр холбогджээ.

Аймгийн төвийн төвлөрсөн шугамд холбогдсон 78 төсөвт байгууллагын 53.8 хувь буюу 42 нь тоолууртай ба 46.2 хувь буюу 36 нь тоолуургүй байна. Нийт 78 байгууллагаас 37 байгууллагын хэрэглэсэн цэвэр, бохир усны тооцоог тоолуураар, 41 байгууллагын төлбөрийн тооцоог тогтмол буюу батлагдсан төсвийн хэмжээгээр тооцож авч байгаа нь ихээхэн хэмжээний орлого алдаж, усны алдагдал болж байгааг харуулж байна. Иймд төсөвт байгууллагуудын цэвэр, бохир усны төлбөрийг тоолуурын заалтаар авах асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Техникийн нөхцөл олгохдоо 2023 оны А/04 тоот “Техникийн нөхцөл олгох комисс томилох тухай” тушаалаар байгуулагдсан комиссын хурлын тэмдэглэл шийдвэр гаргаагүй байгаа нь Зохицуулах хорооноос баталсан “Ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд хэрэглэгчийн холбох техникийн нөхцөл олгох”-ын 4.2, 4.5, 4.7, 4.8, 7.1-д заасныг зөрчсөн байна.

1.2.2 ЦШСГ нь бусад орлогыг үнэн зөв тайлагнаагүй, зарим орлогыг дутуу төвлөрүүлсэн байна

ЦШСГ-ын орлого бүрдүүлэлт, тайлагналын талаар: Нийт орлогын гүйцэтгэл 2023 онд төлөвлөснөөс 99.7 сая төгрөгөөр буюу 0.7%-иар тасарч, 2024 онд 1,293.8 сая төгрөгөөр буюу 7.8%-иар давж биелэгдсэн байна.

Айл, өрх, ААНБ болон түгээлтийн орлого 2023 онд 274.1 сая төгрөгөөр тасарч, 2024 онд 961.0 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна. Хүүгийн орлого 2023 онд 179.6 сая төгрөгөөр илүү, 2024 онд 0.5 сая төгрөгөөр дутуу биелэгдэж, бусад орлого 2023 онд 4.5 сая төгрөгөөр дутуу, 2024 онд 333.3 сая төгрөгөөр илүү төвлөрсөн байна.

Илрүүлэлт:

- ЦШСГ-ын 2023 оны санхүүгийн тайланд авлагаар бүртгэгдэх ёстой 202.9 сая төгрөгийн алдангийг хүүгийн орлогоор тайлагнасан.

- Үйл ажиллагааны бус орлогод хамаарах техникийн нөхцөлийн суурь хураамжийн орлогоос 2023 онд 10.5 сая төгрөг, 2024 онд 10.2 сая төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн.

- ЦШСГ телевизийн болон хогны хураамжийн 2023-2024 оны орлогоос “Орда” СӨХ-ноос 5.9 сая төгрөг, МҮОНРТ-ээс телевизийн хураамжаас 1.5 сая төгрөгийг ЦШСГ-т дутуу төвлөрүүлж, авлагаар тайлагнаагүй.

Аудитын дүнгээр телевизийн хураамжийн орлогоос дутуу төвлөрүүлсэн 1.5 сая төгрөг, хогны хураамжийн орлогоос дутуу төвлөрүүлсэн 5.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, техникийн нөхцөлийн суурь хураамжийн орлогоос дутуу төлүүлсэн 20.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов..

Алтай таван богдын байгалийн цогцолборт газар, Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамжийн тендерийн ажлын тайлагнал, бүртгэл тооцооны талаар:

ЦШСГ нь 2022 онд УТХО-аар Эрчим хүчний сайдын багцаас санхүүжих Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамжаар хангах 4,499.9 сая төгрөгийн, Алтай таван богдын байгалийн цогцолборт газрын цахилгаан хангамжаар хангах 2,399.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан.

ЦШСГ нь дээрх 2 ТАХ-ний ажилд гүйцэтгэлээр 2022 онд 227.2 сая, 2023 онд 2,548.7 сая, 2024 онд 1,539.0 сая төгрөг, нийтдээ 4,315.4 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авсан байна.

2022-2024 онд нийтдээ 4,314.9 сая төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 43.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 3,755.5 сая төгрөгийг зарцуулж, 2024 оны эцэст төслийн дансанд 603.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан. Төсөлтэй холбоотой худалдан авсан бараа материалын үлдэгдэл 2023 онд 220.6 сая төгрөг, 2024 оны үлдэгдэл 569.9 сая төгрөг байна.

Аудитын дүнгээр төсөл арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

1. ЦШСГ нь Хятад улсад 2022-2024 онд баганын үнэд нийтдээ 1,115.7 сая төгрөгийг шилжүүлсэн. Үүнээс “Проект Ватт” ХХК-д 65.0 сая төгрөг, иргэн Алтанцэцэгийн дансанд 1,050.7 сая төгрөг шилжүүлсэн.

ЦШСГ нь 2023.07.14-ний өдөр Хятад улсын Шинжаан Бэйдиан /Нордиан/ Датун ХХК-тай гэрээ байгуулж, 1500 ширхэг баганыг нэг бүрийг нь 980 юанаар худалдан авахаар тохирсон байна. Гэрээнд худалдан авагч тал хилийн боомт хүртэлх тээврийн зардлыг хариуцахаар тусгасан боловч 1 ширхэг баганыг хэдэн юанаар тээвэрлэх талаар тодорхой тусгаагүй байна. 2022. 04.27- 2023.07.07-ны өдөр хүртэл 1030 ширхэг багана гаалиар орж ирсэн бөгөөд санхүүгийн баримтад ямар нэгэн худалдах, худалдан авах гэрээ байхгүй байна.

Датун ХХК-аас 2023.07.14-ний өдрөөс 2024 он хүртэл 633 багана гаалиар орж ирсэн. Үүнээс үзэхэд гэрээ хийгээгүй байхад 1030 ш баганыг худалдан авч гаалиар оруулж ирсэн.

2023.06.10-ны өдөр 800 ширхэг баганыг нэг бүрийг 320 юанаар, 2024.05.20-ны өдөр 700 баганыг 320 юанаар тээвэрлэх, нийлүүлэлтийн хоёр гэрээг Су Кэ гэсэн иргэнтэй байгуулж, Чинхэ боомт хүртэл тээвэрлэх гэрээ ирүүлсэн.

Гэтэл 2023.06.10-ны өдрийг хүртэл 1001 ширхэг баганыг тээвэрлэж дууссан байна. Мөн 2024.03.10-ний өдөр хүртэл нийт 662 ширхэг баганыг Өлгий хүртэл тээвэрлэсэн байна. Иймд дээрх хоёр гэрээ нь цаг хугацааны хувьд ямар ч уялдаагүй, тээвэр хийсэн иргэний дансанд мөнгө шилжүүлсэн талаар нотлох баримт байхгүй байна.

Аудитын явцад төслийн инженерээс Алтай таван богд, Хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын чиглэлд 2022 онд 12 метрийн 204 ширхэг, 2023-2024 онд 1567 ширхэг, нийт 1771 ширхэг баганыг суурилуулсан гэсэн тайлбар ирүүлсэн.

Хятад улсаас 1663 ширхэг багана орж ирсэн, “Проект Ватт” ХХК-наас 100 ширхэг багана нийт 1763 ширхэг багана худалдаж авсан байна. Төслийн талбар руу тээвэрлэгдсэн багана, нийт худалдаж авсан баганы хооронд 8 баганын зөрүүтэй байна.

Хятад улс руу 2022-2024 онуудад баганы үнэд нийтдээ 1,050.7 сая төгрөг шилжүүлсэн. Үүнээс гаалийн мэдүүлгээр баталгаажсан импортоор орж ирсэн баганы тоо 1663 ширхэг, гаалийн мэдүүлэг дэх барааны мөнгөн дүн 868,079 юань бөгөөд нийт 34 удаагийн гаалийн мэдүүлгийн дунджаар тооцож үзэхэд нэг ширхэг баганы дундаж үнэ 524.16 юань гарч байна.

ГЕГ-аас ирүүлсэн гаалийн мэдүүлэг, холбогдох баримт бичигт ЦШСГ-ын 2023 оны 3 дугаар сарын хоёр төрлийн гэрээ ирүүлсэн. Иймд Хятад улсад баганы үнэд шилжүүлсэн 1,050.7 сая төгрөгт хэдэн ширхэг багана орж ирэх ёстой байсныг аудитын явцад тогтоох боломжгүй байгаа тул хуулийн байгууллагаар шалгуулах нь зүйтэй гэж үзсэн.

2. Хятад улсын Эрээн хотод бусад дагалдах сэлбэг хэрэгсэл худалдан авахаар 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдөр Yongxing Electric power material ХХК-аас 60 тн AC-50/8 кабел утас 1 тн утасны үнэ 16,800 юань нийт 1,008,000 юань, 2024.01.18-ны өдөр Yongxing Electric power material ХХК-аас нийт 595,675 юаны дагалдах сэлбэг хэрэгсэл, 2 компанитай гэрээ байгуулж бусад сэлбэг хэрэгсэл татахаар 2023-2024 онд нийтдээ 1,603,675 юань шилжүүлсэн байна.

ГЕГ-аас ирүүлсэн Замын үүд боомтоор орж ирсэн барааны гаалийн мэдүүлэг болон худалдан авах гэрээнд ЦШСГ нь Yongxing Electric power material ХХК-аас 60 тн AC-50/8 кабел утас 1 тн утасны үнэ 13,000 юань нийт 780,000 юаньаар, Yongxing Electric power material ХХК-аас нийт 417,329 юаны дагалдах сэлбэг хэрэгсэл худалдан авахаар тусгасан байна.

Үүнээс үзэхэд байгууллагын санхүү болон гаалийн байгууллагад хоёр өөр дүнтэй гэрээ байгаа бөгөөд хоёр гэрээний үнийн дүнгийн зөрүү 406,346 юань байгааг аудитын явцад тогтоох боломжгүй байсан тул хуулийн байгууллагаар шалгуулах нь зүйтэй гэж үзсэн.

3. Иргэн Алтанцэцэгийн дансанд 2022.09.30-ны өдөр 58.7 сая төгрөг, 2022.12.23-ны өдөр 30.1 сая төгрөгийг ямар нэгэн гэрээ хийхгүйгээр шилжүүлсэн ба гаалийн татварт 8.4 сая төгрөг төлөгдсөн байна. Энэхүү бараа нь Ховд аймгийн Булган сумын Ярант боомтоор 2023.01.18-ны өдөр 698 уут цемент, 2 дамар кабель утас, 80 хайрцаг щитний хайрцаг, 10 хайрцаг тусгаарлагч шаазан орж ирсэн гэх боловч гаалийн мэдүүлгээр 88.8 сая төгрөгийн бараа орж ирснийг батлах боломжгүй байна. Гэтэл санхүүгийн баримтад 2023.04.15-ны өдрийн бэлтгэн нийлүүлэгч талын зарлагын падааныг үндэслэж, барааг 2023.06.30-ны өдөр орлого авснаар санхүүгийн бүртгэл, тайланд тусгасан.

Ховд аймгийн Булган сумын Ярант боомтоор 2023.01.18-ны өдөр 698 уут цемент орсноор гаалийн мэдүүлэгт тусгагдсан боловч 25 тн буюу 500 уут цемент орж ирснийг хүлээн авсан гэж дарга, нягтлан бодогчид тайлбарласан бөгөөд 198 уут цемент орж ирсэн эсэхийг тогтоох боломжгүй байна.

Аудитын дүнгээр илэрсэн дараах зөрчилд албан шаардлага өгөв. Үүнд:

- ЦШСГ нь хилийн цэргийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамж, Алтай таван богдын байгалийн цогцолборт газрын цахилгаан хангамж төслийн арга хэмжээнд 2022-2024 онд нийтдээ 4314.9 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан боловч санхүүгийн тайланд орлогоор бүртгэж тайлагнаагүй, зардлыг бүртгээгүй, дуусаагүй барилга байгууламжид бүртгэж тайлагнаагүй."Проект ватт" ХХК-аас худалдан авсан 100 ширхэг, Хятад улсаас худалдан авсан 1663 ширхэг, нийт 1763 ширхэг цахилгааны шугамын баганыг орлого аваагүй,

- Алтай таван богдын байгалийн цогцолборт газрын цахилгаан хангамжийн ажилд 2023 онд 314.5 сая төгрөгийн, 2024 онд 746.3 сая төгрөгийн, ХЦ-ийн 0165 дугаар ангийн 1, 2 дугаар заставын цахилгаан хангамжийн ажилд 2023 онд 414.7 сая төгрөгийн, 2024 онд 541.2 сая төгрөгийн буюу 2024 оны жилийн эцэст нийтдээ 1,287.5 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд бүртгэж тайлагнасан. Санхүүгийн программаас өглөг үүсэн байдлыг шалгаж үзэхэд энэ нь нийт хүлээж авсан санхүүжилт, төслийн зардал хоёрын зөрүүгээр өглөг тайлагнасан нь бодитой биш бөгөөд, бичилтийн алдаанаас үүдэлтэй өглөгийг бүртгэж тайлагнасан.

- Төслийн ажилд 2023 онд Голомт банкнаас 295.0 сая төгрөгийн, аж ахуйн нэгж, иргэдээс 618.9 сая төгрөгийн, 2024 онд 608.0 сая төгрөгийн, нийтдээ 1,521.9 сая төгрөгийн зээл авч, 82.2 сая төгрөгийн зээлийн хүүгийн зардал гаргасан. Энэхүү зээлийг авахдаа ЦШСГ-ын Удирдах зөвлөлд танилцуулж, зохих зөвшөөрөл аваагүй.

- Иргэн Алтанцэцэгийн дансанд 2022.09.30-ны өдөр 58.7 сая төгрөгийг, 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр 30.1 сая төгрөгийг ямар нэгэн гэрээ хийхгүйгээр сэлбэг худалдан авахаар шилжүүлсэн, "Өлгий бид" ХХК-д 2024.01.05-ны өдөр 9.0 сая төгрөг шилжүүлсэн бөгөөд гүйлгээ хийсэн төлбөрийн даалгавар, санхүүгийн анхан шатны баримт байхгүй, ямар нэг бараа материал орлого аваагүй, санхүүгийн тайланд авлагаар бүртгэж харуулаагүй.

- Дээрх 2 төслийн санхүүжилтийн гүйцэтгэлийг шалгаж үзэхэд гаалийн мэдүүлэг болон барааны гэрээ, тээврийн гэрээ зэрэг анхан шатны баримтыг бүрэн гүйцэт баримтад хавсаргаагүй, Хятад улсад баганын үнийг иргэн Алтанцэцэгт шилжүүлэхдээ хэдэн баганын үнэ шилжүүлж байгаа нь тодорхой бус, шилжүүлсэн мөнгөн дүнд тохирсон багана гаалиар хэзээ орж ирснийг тэмдэглээгүй, мөн баганын тээврийг тооцоог гаргаж хавсаргаагүй, тээвэр хийсэн иргэдээс цахим е-баримтыг авч санхүүгийн баримт материалд хавсаргаагүй, бүртгэл, тооцоо, тайлагналыг зохих журмаар хийгээгүй, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хангалтгүй зохион байгуулсан.

Мөн гаалиар орж ирсэн цементийг данс бүртгэлд тусгаагүй, ажилчдад тараасан боловч үнийг нь дансанд оруулаагүй, авлагаар бүртгэж харуулаагүй 498 уут цементийн үнэ нэг бүрийн 13,500 төгрөгөөр тооцож 6.7 сая төгрөгийг нэр бүхий ажилчдаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

"Суат ХХК"-ны цэвэр бохир усны шинэ хэрэглэгч 2023 онд 230, 2024 онд 256 нэмэгдсэн ба нийт орлого нь гүйцэтгэлээр 2023 онд 9 хувиар буюу 150.8 сая төгрөгөөр, 2024 онд 3.7 хувиар буюу 87.7 сая төгрөгөөр өссөн байна.

Орлогын гүйцэтгэлийг салбараар нь авч үзвэл 2023 онд орон сууц, гэр хорооллын айл, өрхийн орлого 63.4 сая төгрөгөөр, төсөвт байгууллагын орлого 49.1 сая төгрөгөөр, халуун усны түрээсний орлого 39.2 сая төгрөгөөр, аж ахуйн нэгжийн

орлого 0.3 сая төгрөгөөр нийтдээ 152.1 сая төгрөгөөр давж, бусад орлого 1.3 сая төгрөгөөр тасарсан.

2024 онд халуун усны түрээсний орлого 69.8 сая төгрөгөөр, орон сууц, гэр хорооллын айл, өрхийн орлого 55.4 сая төгрөгөөр, бусад орлого 14.4 сая төгрөгөөр нийтдээ 139.6 сая төгрөгөөр давж, төсөвт байгууллагын орлого 43.8 сая төгрөгөөр, аж ахуйн нэгжийн орлого 8.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний зохицуулах хорооны 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 87 дугаар тогтоолоор төсөвт байгууллагын цэвэр бохир усны үнэ тарифыг нэмж, бусад байгууллага, айл өрхийн үнэ тарифыг дараа сарын 01-ний өдрөөс нэмэгдэж, төсөв байгууллагын нэмэгдсэн үнэ тарифыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж ажиллахаар тогтоосон ба цэвэр усны үнэ тариф 54.2-62.5 хувиар, бохир усны үнэ тариф 54.2-62.5 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Авлага өмнөх оноос 2023 онд 70.9 сая төгрөгөөр, 2024 онд 93.1 сая төгрөгөөр нэмэгдсэн ба 2024 оны жилийн эцсийн байдлаарх нийт авлагын 28.8 хувийг төсөвт байгууллагын, 29.7 хувийг аж ахуйн нэгжийн, 31.8 хувийг айл өрхийн, 9.6 хувийг бусад авлага эзэлж байна.

1.2.3 Удирдлагын зардлыг тусад нь төлөвлөж, зарцуулалтыг хянаж ажиллаагүй байна

ЦШСГ нь 2023-2024 бизнес төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайланд удирдлагын зардлыг тусдаа төлөвлөж, тайлагнаагүй, үйл ажиллагааны зардалтай хамт төлөвлөж, тайлагнаж байгаа нь удирдлагын зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд үнэн зөв дүгнэлт өгөх боломжгүй байна.

“Суат” ХХК-ний удирдлагын зардалд 2023 онд 271.5 сая төгрөг төлөвлөгдөж гүйцэтгэлээр 271.8 сая төгрөг зарцуулан 0.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн, 2024 онд 404.3 сая төгрөг төлөвлөгдөж гүйцэтгэлээр 359.1 сая төгрөг зарцуулан 45.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Удирдлагын зардлыг 2023 онд өмнөх оноос 37.7 сая төгрөгөөр буюу 16.1 хувиар, 2024 онд өмнөх оноос 132.7 сая төгрөгөөр буюу 48.8 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн нь захиргааны зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөөгүй байгаа нь харагдаж байна. Аудитаар дараах зөрчлүүд илэрсэн: Үүнд:

➤ Гүйцэтгэх захирал нь 2023-2024 онд 685.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлтийг захирлын тушаалаар, 2024 онд ур чадварын нэмэгдэл 25 хувиар бодож 7,034.8 мянган төгрөг, нийт 7,719.8 мянган төгрөгийн нэмэгдлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэргүйгээр эрх хэмжээгээ хэтрүүлж, хууль зөрчиж авсан.

➤ Гүйцэтгэх захирал нь 7799 БӨА дугаартай Lexus 470 суудлын авто машинаар 2023 онд 1632 литр буюу 4.5 сая төгрөгийн, 2024 онд 1455 литр буюу 4.1 сая төгрөгийн шатахууныг хот дотор ямар ажлаар явсан тодорхойгүй, жолоочийн тооцооны хуудсыг спидометрийн заалтгүй зэрэг үр ашиггүй зарцуулсан.

➤ Нярав нь аж ахуй, бараа материалын тайланг зохих журмын дагуу гаргаагүй, жолоочийн шатахууны тооцоог зохих журмын дагуу хийгээгүй, кассын анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй.

1.2.4. Үр ашиггүй зардлыг бууруулах, ашигт ажиллагааг дээшлүүлэх талаар хангалтгүй ажилласан байна

ЦШСГ-ын үйл ажиллагааны зардал (тарифт зардал)-ыг 2023 онд төлөвлөснөөс 161.4 сая төгрөгөөр, 2024 онд 22.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Цалингийн зардлыг 2023 онд 14.8 сая төгрөгөөр хэтрүүлж, 2024 онд 1.5 сая төгрөгөөр хэмнэсэн байна. 2023 онд урсгал засварыг 30.6 сая төгрөгөөр, гадны үйлчилгээний хөлс 11.7 сая төгрөгөөр, элэгдлийн зардлыг 149.1 сая төгрөгөөр хэтрүүлж, төлөвлөгдөөгүй үйл ажиллагааны бус 21.2 сая төгрөгийн зардал гаргасан.

2024 онд урсгал засвар 13.7 сая төгрөгөөр, албан томилолт 4.7 сая төгрөгөөр, гадны үйлчилгээний хөлс 11.0 сая төгрөгөөр, сургалтын зардал 1.1 сая төгрөгөөр, элэгдлийн зардал 202.9 сая төгрөгөөр хэтэрч, бусад зардлыг төлөвлөсөн хэмжээнд зарцуулсан байна.

Илрүүлэлт:

- Кассаас цохолт хийсэн 1, 2 дугаар гарын үсгийн аль нэг нь дутуу, бэлэн мөнгө, шагнал, тусламж олгохдоо хүлээн авсан хүний гарын үсэг дутуу, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 61.6 сая төгрөгийг бэлэн олгосон,
- Ажилчдын цалингаас 2023 онд ҮЭ-ийн татварт 14.1 сая төгрөгийн суутгал хийж, 19.9 сая төгрөг зарцуулж, суутгасан дүнгээс 5.0 сая төгрөгийг илүү зарцуулсныг авлагаар тусгаагүй байгууллагын зардлаас гаргасан, 2024 онд 18.9 сая төгрөгийн ҮЭ-ийн татвар суутгасан боловч орлого, зарлагын тооцоог хийгээгүй байна.
- Аудитаар сахилгын шийтгэлтэй хугацаанд олгосон 2.8 сая төгрөгийн урамшуулал, байгууллагаас төлсөн 5.8 сая төгрөгийн актын төлбөр, суутгаагүй цалингийн урьдчилгаа 24.8 сая төгрөг, суутгаагүй 1.0 сая төгрөгийн ХХОАТ, дутуу төвлөрүүлсэн 20.7 сая төгрөгийн техникийн нөхцөлийн суурь хураамж, гэрээний дүнгээс илүү шилжүүлсэн 5.0 сая төгрөг, ажиллагсдын эрүүл мэндийн үзлэгт нотлох баримтгүй "Өлгий таван гал" ХХК-д шилжүүлсэн 4.8 сая төгрөгийн зөрчилд акт тогтоов.
- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулсан 80.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

“Суат” ХХК-ний үйл ажиллагааны зардалд 2023 онд 1,383.6 сая төгрөг төлөвлөгдөж гүйцэтгэлээр 1,488.8 сая төгрөг зарцуулан 105.2 сая төгрөгөөр хэтрүүлэн, 2024 онд 1781.1 сая төгрөг төлөвлөгдөж гүйцэтгэлээр 1770.0 сая төгрөг зарцуулан 11.1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Тус компанийн үйл ажиллагааны зардлыг тооцоо судалгаанд үндэслэж бодитой төлөвлөөгүй байна.

Сангийн яам 2022 оноос аймгийн орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс тус компанийн хугацаа хэтэрсэн урт хугацаат зээлийн төлбөрт 2022-2024 онд нийтдээ 568.8 сая төгрөгийг суутган төлүүлсэн. Энэхүү зээлийг барагдуулах талаар арга хэмжээг төлөвлөж ажиллаагүй байна.

Бэлэг дурсгал, шагнал, урамшуулал, хүлээн авалтын зардалд 2023 онд 5.6 сая төгрөгийн, 2024 онд 6.5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулж үргүй зардал гаргасан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

“Суат” ХХК-ны ТУЗ-ээс 2023 онд компанийн бүтэц орон тоог 75, 2024 онд 76 орон тоогоор баталсан байна. Компанийн бүтцийг 3 алба, 4 хэсэгтэй байхаар баталсан ба менежер, хүний нөөцийн менежер бөгөөд захиргаа удирдлагын хэлтсийн дарга, тоолуурын техникч, засварчин, борлуулалтын ажилтан гэх мэт орон тооны чиг үүргийн давхардал нь ажиллагсдын цалин нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэхэд, байгууллагын зардлын хэмнэлтэд, бүтээмжийг дээшлүүлэх үйл явцад нөлөөлж байна.

1.2.5.Худалдан авах ажиллагааг төлөвлөж ажиллаагүй байна

Цахилгаан шугам сүлжээний газар, “Суат” ХХК нь худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу төлөвлөгөө батлуулж хэрэгжүүлэлгүй, цахим дэлгүүрийн системийг ашиглаагүй, бараа материал, хөрөнгийг гэрээгээр шууд худалдан авалт хийсэн байна.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ДОТООД ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА

2.1ХЯНАЛТЫГ ЗОХИХ ТҮВШИНД ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН БАЙНА

2.1.1. Эрх бүхий байгууллагуудаас хяналт шалгалт хийгдсэн байна

ЭХЗХ нь ЦШСГ-ын 2023-2024 оны цахилгаан түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтийг дүгнэж ажилласан байна.

Цахилгаанаар түгээх, цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хүрээнд 2023 онд дэвшүүлсэн 6 зорилтыг хянаж 80%-ийн, 2024 онд дэвшүүлсэн 5 зорилтыг хянаж 87.6%-ийн биелэлттэй гэж **“сайн”** үнэлгээтэй гэж дүгнэсэн байна.

Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хүрээнд 2023 онд дэвшүүлсэн 5 зорилтыг 80.7%-ийн, 2024 онд дэвшүүлсэн 6 зорилтыг 76.7%-ийн биелэлттэй **“сайн”** үнэлгээтэй гэж дүгнэсэн байна.

“Суат” ХХК-ны 2023, 2024 оны үйл ажиллагаанд дараах төрийн байгууллагуудаас хяналт шалгалт хийсэн байна.

Хот суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооноос 2025 оны 8 дугаар сард Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, усны үйлчилгээний тогтвортой байдал, үнэ тарифын хэрэгжилтийг шалгах удирдамжаар 2024 болон 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.

2.1.2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас шалгалт хийсэн байна

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Цахилгаан шугам сүлжээний газар, “Суат” ХХК-ны 2023-2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн байна.

“Суат” ХХК-д хийсэн шалгалтаар тогтоосон 38.5 сая төгрөгийн төлбөрийн 6 актыг төлбөр хариуцагчаас Сангийн сайдад хүчингүй болгуулах гомдлыг гаргаж, Сангийн яам актууд нь Захиргааны Ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.2, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2-т заасныг бүрэн хэрэгжүүлээгүй гэж үзэн хүчингүй болгон шийдвэрлэсэн байна.

2.2. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА

2.2.1 ТУЗ-өөс хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна

Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс хараат бусаар хяналт шалгалт хийх эрх бүхий дотоод аудитор томилж ажиллуулаагүй, төлөөлөн удирдах зөвлөлөөс хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2.2. Дотоод хяналтыг үр нөлөөтэй төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна

ЦШСГ-ын дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлтийг гаргаагүй, хийсэн ажлаа Удирдах зөвлөлд танилцуулаагүй, ажлын тайлан гэх 2 хуудас тайлан бичсэн боловч нотлох баримтгүй, төлөвлөгөөнд заасан ажлуудыг тусгаагүй байна.

“Суат” ХХК-ийн бүтэц орон тоонд 2016 оноос эдийн засагч, дотоод аудиторын орон тоог бий болгож ажиллуулж ирсэн байна. Дотоод аудитын ажлын төлөвлөлт, хэрэгжилттэй холбоотой баримт материал аудитад ирүүлээгүй. Дотоод аудиторын үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах асуудал хангалтгүй байна.

Илрүүлэлт:

Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүд дотоод хяналт шалгалтын журмыг хэрэгжүүлээгүй, дотоод хяналт шалгалт нэр төдий хийгдсэн байна.

2.2.3. Шилэн дансны зарим мэдээллийг ил тод байршуулаагүй байна

ЦШСГ нь <https://ulgiienergy.mn/> вэб сайтаар компанийн танилцуулга, тусгай зөвшөөрөл, үнэ тариф, удирдах албан тушаалтнуудын танилцуулга, бүтэц зохион байгуулалт, ТУЗ-ийн урамшууллын мэдээллийг байршуулсан. “Olgiiotog” нэртэй

Facebook пейж хуудас ажиллуулж, өдөр тутмын мэдээ, мэдээллийг байршуулсан байна.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс 149 мэдээллийг хугацаандаа мэдээлж, 5 мэдээллийг хугацаа хоцроосон бол 6 мэдээллийг мэдээлээгүй байна.

“Суат” ХХК нь 2025 оноос вэбсайтыг шинэчилж suat-llc.mn гэсэн шинэ сайтыг нэвтрүүлж, “Баян-Өлгий аймгийн НААҮ-ний “Суат” ХХК гэсэн цахимыг хуудсыг нээн ажиллуулсан байна.

Шилэн дансанд 2023 онд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг хаягийг тухай бүрд нь мэдээлсэн байх ёстой боловч 159.8 сая төгрөгийн 24 гүйлгээний мэдээлэл, мөн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэртэй холбоотой 2023 онд 57.6 сая төгрөгийн 32 шийдвэр, 2024 онд 51.6 сая төгрөгийн 32 шийдвэрийг ил тод байршуулаагүй зөрчилд албан шаардлага өгөв.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. ОНӨААН-үүдийн засаглал, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх талаар үр дүнтэй бодлого, шийдвэр гаргаж ажиллаагүй байна.
2. Үйл ажиллагааны эдийн засгийн үзүүлэлтүүдийг бодитой төлөвлөөгүй, зорилт түвшний зарим үзүүлэлтийг хангаж ажиллаагүй байна.
3. Удирдлагын зардлыг тусад нь төлөвлөж, үр ашигтай зарцуулах талаар хангалтгүй ажилласан байна.
4. Үйл ажиллагааны зардлыг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, үр ашиггүй зардлыг бууруулах талаар хангалтгүй ажилласан байна.
5. ЦШСГ-ын тендерийн орлого, зардлын бүртгэлийг үнэн зөв хөтөлж, ашигт ажиллагааг тооцож тайлагнаагүй байна.
6. Худалдан авах ажиллагааг зохих журмаар төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна.
7. Дотоодын хяналтыг үр нөлөөтэй төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. Цахилгаан шугам сүлжээний газрын дарга /Ө.Арманбек/-д:

1. Үйл ажиллагааны орлого, зардлыг үндэслэлтэй төлөвлөх, удирдлагын зардлыг тусад нь төлөвлөх, бизнес төлөвлөгөө, хүрэх түвшнийг эдийн засгийн үзүүлэлт тус бүрээр ТУЗ-ийн тогтоолын хавсралтаар батлуулж ажиллах;
2. Үйл ажиллагааны болон удирдлагын зардлыг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, ашигт ажиллагааг дээшлүүлэхэд анхаарах;
3. Бусад орлогыг санхүүгийн тайланд үнэн зөв тусгах, Үйлдвэрчний эвлэлийн орлого, зарцуулалтын тооцоог баталгаажуулж байх;
4. Ажиллагсдын ажлыг үнэлэх, дүгнэх журам баталж, ажлын үр дүнг бодитой дүгнэж байх;
5. Байгууллагын дотоод хяналт шалгалтын журмыг шинэчлэн баталж, дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх;

II. “Суат” ХХК-ийн гүйцэтгэх захирал /С.Нурбек/-д

1. Компанийн орлого, зардлын эдийн засгийн үзүүлэлтүүдийг үндэслэлтэй төлөвлөж, батлуулах;
2. Төсөвт байгууллагын усны төлбөрийг тоолуурын заалтаар авах асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх, төлбөрт үйлчилгээний орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах;
3. Зардал хэмнэх, үр ашиггүй зардлыг бууруулах, ашигт ажиллагааг дээшлүүлэхэд анхаарах;
4. Дотоод хяналтыг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжүүлж ажиллах;

III. Цахилгаан шугам сүлжээний газрын Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. Цахилгаан шугам сүлжээний газрын засаглал, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх талаар бодлого, шийдвэр гаргаж ажиллах

IV “Суат” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд:

1. Компанийн эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт, хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавьж ажиллах, үр ашгийг дээшлүүлэх;
2. Компанийн гүйцэтгэх захиралд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг боловсруулж батлах;